

Булган сумын Сөнхөл багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын Сөнхөл багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2025/190/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2025 он	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn “Анализ старт аудит” ХХК-ийн захирал: Н.Энхтуяа Утас:99075818 Цахим хаяг:asaudit.mn@gmail.com
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
 3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
 4. Аудитын тайлан
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2024.02.21 № 68
танай _____-ны № _____-т

БУЛГАН СУМЫН СӨНХӨЛ БАГИЙН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Д.АМГАЛАН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын Сөнхөл багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Булган сумын Сөнхөл багийн Ерөнхий боловсролын сургууль нь 2024 онд 801.4 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 761.7 сая төгрөг зарцуулж, 95.0 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

832502000098

Бусад асуудал

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ж.АЙГҮЛ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>133,933,135.02</u>	<u>58,519,229.52</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	113,906,077.72	39,732,877.72
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	113,906,077.72	39,732,877.72
3121	Төгрөг	113,906,077.72	39,732,877.72
31211	Төрийн сангийн харилцах	113,906,077.72	39,732,877.72
35	БАРАА МАТЕРИАЛ	20,027,057.30	18,786,351.80
354	Хангамжийн материал	20,027,057.30	18,786,351.80
35410	Бичиг хэргийн материал	00.00	60,770.00
35420	Аж ахуйн материал	8,694,500.00	8,419,580.00
35440	Түлш, шатах тослох материал	4,011,350.00	1,536,450.00
35460	Хүнсний материал	7,321,207.30	5,379,291.80
35470	Бусад хангамжийн материал	00.00	3,390,260.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>681,731,620.27</u>	<u>724,921,493.95</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	681,731,620.27	724,921,493.95
392	Биет хөрөнгө	669,419,543.22	712,894,064.70
39201	Барилга, байгууламж, орон сууц	712,673,172.16	712,673,172.16
39202	Хуримтлагдсан элэгдэл	-75,434,046.00	-99,332,955.84
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	33,180,876.00	97,210,741.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-11,542,326.75	-20,061,030.86
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,511,500.00	32,545,100.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,402,257.45	-12,400,829.26
39214	Бусад үндсэн хөрөнгө	649,980.00	649,980.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-423,318.74	-488,316.74
39217	Ном	1,205,964.00	2,098,204.24
393	Биет бус хөрөнгө	12,312,077.05	12,027,429.25
39301	Програм хангамж	1,423,239.00	1,423,239.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-71,161.95	-355,809.75
39303	Бусад биет бус хөрөнгө	10,960,000.00	10,960,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>815,664,755.29</u>	<u>783,440,723.47</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>32,293,500.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	32,293,500.00
413	Өглөг	00.00	32,293,500.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	13,179,000.00
4136	Бусад өглөг	00.00	19,114,500.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	19,114,500.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>815,664,755.29</u>	<u>751,147,223.47</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	815,664,755.29	751,147,223.47
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	95,629,950.00	95,629,950.00
51101	Өмч: - төрийн	95,629,950.00	95,629,950.00
512	Хуримтлагдсан үр дүн	662,605,745.77	598,088,213.95
51210	Өмнөх үеийн үр дүн	662,605,745.77	662,605,745.77
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-64,517,531.82
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	57,429,059.52	57,429,059.52
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>815,664,755.29</u>	<u>783,440,723.47</u>

Булган сумын Сөнхөл багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	630,914,039.00	731,778,145.24
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	44,236,245.24
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	44,236,245.24
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан-ҮХ	00.00	38,296,705.24
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан- БМ	00.00	5,939,540.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	630,914,039.00	687,541,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	595,358,039.00	647,154,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	569,578,800.00	647,154,900.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	25,779,239.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	35,556,000.00	40,387,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	35,556,000.00	40,387,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	548,474,612.39	796,295,677.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	548,474,612.39	796,295,677.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	538,708,112.39	786,686,677.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	402,133,636.73	607,560,900.00
210101	Үндсэн цалин	288,822,630.04	406,942,270.02
210102	Нэмэгдэл	99,709,188.06	182,258,429.98
210104	Урамшуулал	13,601,818.63	18,360,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,464,065.00	74,297,900.00
210201	Тэтгэврийн даатгал	30,678,724.00	50,522,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,204,395.00	5,943,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,550,821.00	2,972,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	687,422.00	2,972,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,342,703.00	11,887,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,502,050.02	41,961,900.00
210301	Гэрэл, цахилгаан	1,431,100.00	6,200,900.00
210302	Түлш, халаалт	30,070,950.02	35,761,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,284,100.00	5,439,850.00
210401	Бичиг хэрэг	1,284,100.00	1,266,850.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	4,173,000.00
2105	Нормативт зардал	18,427,599.50	15,449,415.50
210502	Хоол, хүнс	18,007,599.50	15,449,415.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	420,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,385,000.00	1,240,000.00
210604	Урсгал засвар	1,385,000.00	1,240,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	853,800.00	935,696.40
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	853,800.00	935,696.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,657,861.14	39,801,015.16
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,966,450.00	3,525,183.60
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,014,000.00	510,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	31,677,411.14	35,765,831.56
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,766,500.00	9,609,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,766,500.00	9,609,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	9,766,500.00	9,609,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	82,439,426.61	-64,517,531.82

Булган сумын Сөнхөл багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>605,134,800.00</u>	<u>687,541,900.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	605,134,800.00	687,541,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	569,578,800.00	647,154,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	569,578,800.00	647,154,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	35,556,000.00	40,387,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	35,556,000.00	40,387,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>507,405,254.73</u>	<u>740,170,600.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	507,405,254.73	740,170,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	497,638,754.73	730,561,600.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	395,676,589.73	594,381,900.00
210101	Үндсэн цалин	282,365,583.04	402,312,100.00
210102	Нэмэгдэл	99,709,188.06	173,709,600.00
210104	Урамшуулал	13,601,818.63	18,360,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,464,065.00	74,297,900.00
210201	Тэтгэврийн даатгал	30,678,724.00	50,522,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,204,395.00	5,943,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,550,821.00	2,972,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	687,422.00	2,972,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,342,703.00	11,887,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,016,000.00	39,487,000.00
210301	Гэрэл, цахилгаан	3,816,000.00	3,816,000.00
210302	Түлш, халаалт	31,200,000.00	35,671,000.00
2105	Нормативт зардал	13,312,500.00	13,507,500.00
210502	Хоол, хүнс	13,312,500.00	13,507,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	540,000.00	900,000.00
210604	Урсгал засвар	540,000.00	900,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	853,800.00	1,181,696.40
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	853,800.00	1,181,696.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,775,800.00	6,805,603.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,495,100.00	5,631,003.60
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,280,700.00	1,174,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,766,500.00	9,609,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,766,500.00	9,609,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	9,766,500.00	9,609,000.00

Булган сумын Сөнхөл багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>97,729,545.27</u>	<u>-52,628,700.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	11,239,900.00	21,544,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,239,900.00	21,544,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	11,239,900.00	21,544,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,239,900.00	21,544,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-11,239,900.00</u>	<u>-21,544,500.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	86,489,645.27	-74,173,200.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	27,416,432.45	113,906,077.72
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	113,906,077.72	39,732,877.72

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	95,629,950.00	57,429,059.52	551,959,842.53	705,018,852.05
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	95,629,950.00	57,429,059.52	551,959,842.53	705,018,852.05
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	28,206,476.61	28,206,476.61
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	95,629,950.00	57,429,059.52	662,605,745.77	815,664,755.29
D01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	95,629,950.00	57,429,059.52	662,605,745.77	815,664,755.29
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	95,629,950.00	57,429,059.52	662,605,745.77	815,664,755.29
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-64,517,531.82	-64,517,531.82
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	95,629,950.00	57,429,059.52	598,088,213.95	751,147,223.47

Булган сумын Сөнхөл багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		27,416,432.45		113,906,077.72
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	633,051,300.00	518,645,154.73	801,447,800.00	761,715,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	633,051,300.00	518,645,154.73	801,447,800.00	761,715,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	621,030,500.00	508,878,654.73	750,381,300.00	721,328,100.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	488,443,100.00	395,676,589.73	623,365,900.00	594,381,900.00
210101	Үндсэн цалин	325,085,000.00	282,365,583.04	430,726,500.00	402,312,100.00
210102	Нэмэгдэл	138,658,000.00	99,709,188.06	174,279,200.00	173,709,600.00
210104	Урамшуулал	24,700,100.00	13,601,818.63	18,360,200.00	18,360,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,055,900.00	44,464,065.00	77,920,900.00	74,297,900.00
210201	Тэтгэврийн даатгал	41,518,200.00	30,678,724.00	52,986,100.00	50,522,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,884,400.00	3,204,395.00	6,233,700.00	5,943,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,907,500.00	2,550,821.00	3,116,900.00	2,972,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	976,900.00	687,422.00	3,116,900.00	2,972,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,768,900.00	7,342,703.00	12,467,300.00	11,887,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,016,000.00	35,016,000.00	39,487,000.00	39,487,000.00
210301	Гэрэл, цахилгаан	3,816,000.00	3,816,000.00	3,816,000.00	3,816,000.00
210302	Түлш, халаалт	31,200,000.00	31,200,000.00	35,671,000.00	35,671,000.00
2105	Нормативт зардал	15,606,000.00	13,312,500.00	19,475,600.00	13,507,500.00
210502	Хоол, хүнс	15,606,000.00	13,312,500.00	19,475,600.00	13,507,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	540,000.00	540,000.00	900,000.00	900,000.00
210604	Урсгал засвар	540,000.00	540,000.00	900,000.00	900,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	853,800.00	853,800.00	2,870,200.00	2,870,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	853,800.00	853,800.00	2,870,200.00	2,870,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,515,700.00	19,015,700.00	26,748,700.00	26,661,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,235,000.00	17,735,000.00	25,574,100.00	25,487,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,280,700.00	1,280,700.00	1,174,600.00	1,174,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,020,800.00	9,766,500.00	10,679,500.00	9,609,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,020,800.00	9,766,500.00	10,679,500.00	9,609,000.00

Булган сумын Сөнхөл багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,020,800.00	9,766,500.00	10,679,500.00	9,609,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-	801,447,800.00	687,541,900.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-	647,154,900.00	647,154,900.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	569,578,800.00	569,578,800.00	647,154,900.00	647,154,900.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-	40,387,000.00	40,387,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	35,556,000.00	35,556,000.00	40,387,000.00	40,387,000.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	-	113,905,900.00	-
1E+06	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	-	-	113,905,900.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	27,416,432.45	00.00	113,906,077.72
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	113,906,077.72	00.00	39,732,877.72

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Булган сумын Сөнхөл багийн ерөнхий боловсролын сургууль нь ерөнхий боловсрол олгох чиг үүрэгтэй байгууллага юм. Тус сургууль нь 2024 онд "Хүүхдийн амжилттай суралцах бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж, хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах" зорилгын хүрээнд 8 зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Булган сумын Сөнхөл багийн ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын Ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг зарим хууль тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлтүүд орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Боловсролын ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас санхүүгийн баримтын шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Булган сумын Сөнхөл багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган сумын Сөнхөл багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сургуулийн захирлын 2024 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/03 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашигладаг бөгөөд уг баримт бичгийг шинээр гарсан хууль эрхийн актуудтай нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Булган сумын Сөнхөл багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны 229 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 32.2 сая төгрөгөөр буюу 4.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	113,906.08	39,732.88	(74,173.20)
Бараа материал	20,027.06	18,786.35	(1,240.71)
Үндсэн хөрөнгө	681,731.62	724,921.49	43,189.87
Нийт хөрөнгө	815,664.76	783,440.72	(32,224.03)
Өр төлбөр	-	32,293.50	32,293.50
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	815,664.76	751,147.22	(64,517.53)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	815,664.76	783,440.72	(32,224.03)

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгө оны эцэст 39.7 сая төгрөг үлдэгдэлтэй гарч, оны эхнээс 74.2 сая төгрөгөөр буурсан байна. Цалингийн болон нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын төсвөөс 32.7 сая, дотуур байрны үйлчилгээнээс 6.0 сая төгрөг, үдийн хоолны зардлаас 1.0 сая төгрөг зарцуулагдаагүй үлдсэн байна.

Бараа материал данс оны эцэст 18.8 сая төгрөг болж, оны эхнээс 1.2 сая төгрөгөөр буурсан байна. Бичиг хэргийн материал 0.06 сая төгрөгийн Аж ахуйн материал 8.4 сая төгрөгийн, Түлш 1.5 сая төгрөгийн, Хүнсний материал 5.4 сая төгрөгийн, бусад хангамжийн материал 3.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 724.9 сая төгрөг болж, 43.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 40.6 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан, үнэ төлбөргүй хүлээн авсан 38.3 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, үндсэн хөрөнгөд 35.7 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Өр төлбөр данс оны эцэст 32.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж, оны эхнээс 32.3 сая төгрөгөөр өссөн байна.

Булган сумын Сөнхөл багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 751.1 сая төгрөг болж, 64.5.6 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 64.5 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Сургуулийн 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 761.0 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 40.4 сая төгрөг, нийт зарлагыг 801.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас сургуулийн 2024 оны хувьсах зардлын төсвийг 551.8 сая төгрөгөөр хянаж, 35.8 сая төгрөгөөр бууруулан баталсан ба төсвийн тодотголоор 79.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 631.7 сая төгрөг болгон тодотгон баталжээ.

Орон нутгийн төсвөөс авах тогтмол зардлын төсвийг 40.4 сая төгрөгөөр хянаж, баталсан ба тодотгол хийгдээгүй байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 761.0 сая төгрөгийг улсын төсвөөс, 40.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, нийтдээ 801.4 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 721.3 сая, орон нутгийн төсвөөс 40.4 сая, нийт 761.7 сая төгрөгийн санхүүжилт авч, оны эхний үлдэгдлээс 113.9 сая төгрөг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 761.7 сая төгрөг болж, 95.0 хувийн биелэлттэй, 39.7 сая төгрөгийн дансны үлдэгдэлтэй гарсан байна. Төсвийн харилцах дансанд их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй гарсан нь төсвийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр арга хэмжээний нэр	Код	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Байр ашиглалтын үйлчилгээ	80226	293.70	293.70	-	100.0%
2	Хүүхэд хамгаалал	80233	310.80	310.80	-	100.0%
3	Сургалт семинар	80312	195.80	195.80	-	100.0%
4	Эрүүл мэндийг дэмжих	81605	293.70	293.70	-	100.0%
5	Үдийн цай хөтөлбөр	81801	10,679.50	9,609.00	1,070.50	90.0%
6	Дотуур байрны үйлчилгээ	81806	139,232.70	133,264.60	5,968.10	95.7%
7	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	81816	19,114.50	19,114.50	-	100.0%
8	Боловсролын байгууллагын багш ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх	81823	880.90	880.90	-	100.0%
9	Боловсролын стандарт сургалтын үйл ажиллагаа	81834	569,912.40	537,218.30	32,694.10	94.3%
10	Сургалтын хэвийн үйл ажиллагааг	81835	19,567.60	19,567.60	-	100.0%
11	Сургуулийн нэмэлт хөтөлбөр	81875	579.20	579.20	-	100.0%
12	Нийтлэг үйлчилгээ ОН		40,387.00	40,387.00	-	100.0%
	Нийт дүн		801,447.80	761,715.10	39,732.70	95.0%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Булган сумын Сөнхөл багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлийн судалгааны дүн дараах байдалтай байна. Үүнд:

Булган сумын Сөнхөл багийн ерөнхий боловсролын сургууль нь Ахмадын тухай хууль, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан ажиллуулах журам”-ыг хэрэгжүүлээгүй буюу ахмадын сан байгуулж ажиллаагүй байна.

Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө баталж ажиллаагүй байна. Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас 0.9 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлын дансаар 39.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Байгууллагын 2024 оны орон тооны судалгааг гаргуулан авч хянаж үзэхэд Боловсрол, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын 2018 оны А/024/11 дүгээр хамтарсан тушаалаар баталсан төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны жишиг орон тоог баримтлан ажилласан байна. Тус сургуулийн 1-12 дугаар сарын цалин олгох хүснэгтээр 30 хүнд цалин хөлс олгосон байна. Аймгийн Засаг даргын захирамжаар 30 орон тоо батлагдсанаас 30 хүн ажилласан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Сургууль нь тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Булган сумын Сөнхөл багийн ерөнхий боловсролын сургуульд *Pearson /5 дугаар ангийн англи хэл/, Eduten /1-5 дугаар ангийн математик/* хөтөлбөрүүд хэрэгжиж байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Булган сумын Сөнхөл багийн ерөнхий боловсролын сургууль нь 2024 онд 61.7 сая төгрөгийн бараа материал, 40.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Булган сумын Сөнхөл багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Анализ старт аудит” ХХК-ийн аудитор Ц.Оюунтуул, шинжээч Д.Энхцаг нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг компанийн захирал Н.Энхтуяа, дараагийн шатны хяналтыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган сумын Сөнхөл багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Анализ старт аудит” ХХК-д 2024 оны 12 дугаар сарын 29-ны өдрийн 15 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Булган сумын Сөнхөл багийн ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 548.5 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 8.2 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай /*өмнөх оноос улсын төсвийн санхүүжилт ихээхэн өссөн*/ гэж үзсэн учир 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 796.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 11.9 сая төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 29 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлэхэд алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг бүрэн мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн төсвийн зарцуулалт нь Төсвийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Булган сумын Сөнхөл багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланд завсарын аудит хийхэд, дансны код сонголт, цалингийн бичилт, ангилалтай холбоотой 313.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд зөвлөмж өгч, үйлчлүүлэгч байгууллагад Асуудлын бүртгэлээр хүргүүлсэн ба 313.0 сая төгрөгийн алдааг залруулсан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй гарсан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Бичигдээгүй.

5.2 Албан шаардлага

Бичигдээгүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Сургууль нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй /бараа материал 61.7 сая төгрөг, худалдан авсан үндсэн хөрөнгө 40.7 сая төгрөг г.м/ байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44.1-т Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.", 46.1-т "Захиалагч худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ бүрээр харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр тайлагнана." гэсэн заалттай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			

